



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ОРОН НУТГИЙН 2023 ОНЫ НӨХӨН БОЛОН ДАХИН СОНГУУЛЬ ЗОХИОН БАЙГУУЛАХ ЗАРДЛЫН ТӨЛӨВЛӨЛТ, ЗАРЦУУЛАЛТ, ГҮЙЦЭТГЭЛД ХИЙХ АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудитын код: ДГА-2023/53-6-ШТА-ГА

Цахим хуудас: www.audit.mn Сайншанд 2023 он	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий Утас: 70522734 Цахим хаяг: gan-ulzii.t@audit.gov.mn Аудитын менежер: У.Оюунтүлхүүр Утас: 70503020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn Аудитор: М.Дүүрэнжаргал Утас: 70523020 Цахим хаяг: duurenjargalm@audit.gov.mn
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

Агуулга	1
Товчилсон үгийн тайлбар	2
Хүснэгтийн товъёог	2
Дүрслэлийн товъёог	2
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3-4
Ерөнхий мэдээлэл	4
БҮЛЭГ 1. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО СЕХ-ООС БАТАЛСАН ТӨСВИЙГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛАН ЗАРЦУУЛСАН БАЙНА.	5-9
1.1. Сонгуулийн ерөнхий хороо нь аймгийн сонгуулийн хороонд 40.3 сая төгрөгийн санхүүжилтийг төлөвлөж хуваарилсан байна..	5-6
1.2. Аймгийн сонгуулийн хороо нь сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн заавар, аргачлалын дагуу зардлыг хуваарилсан байна.	6-7
1.3. Хуваарилагдсан зардлыг 1.4 сая төгрөгөөр хэмнэж, СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.	7-9
БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН НӨХӨН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАЖ, ХОЛБОГДОХ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН БАЙНА.	9-11
2.1. Орон нутгийн хурлын нөхөн сонгуулийн зардлын гүйцэтгэлийг журмын дагуу бүртгэж, тайлагнасан байна.	
2.2. Аймгийн сонгуулийн хорооноос сумдын зардлын зарцуулалтын талаар зөвлөмж, чиглэл өгч хяналт тавих эрхээ хэрэгжүүлэн ажилласан байна.	9-11
Аудитын дүгнэлт	11

Товчилсон үгийн тайлбар

ТАБ	Төрийн аудитын байгууллага
СЕХ	Сонгуулийн ерөнхий хороо

Хүснэгтийн товъёог:

<i>Утга</i>	<i>Тайлбар</i>
<i>Хүснэгт № 1</i>	<i>Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан төсөө</i>
<i>Хүснэгт № 2</i>	<i>Сонгуулийн зардлын санхүүжилтийн мөнгөн дүн</i>
<i>Хүснэгт № 3</i>	<i>Аймаг болон сумын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл</i>

Графикийн товъёог:

<i>Утга</i>	<i>Тайлбар</i>
<i>График № 1</i>	<i>Сонгуулийн зардлын санхүүжилтийн хэмжээ</i>

АУДИТ ХИЙХ ҮНДЭСЛЭЛ:

Монгол Улсын Аймаг, нийслэл, сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.8 “Энэ хуулийн 10.6-д заасан зардлын төлөвлөлт, зарцуулалт, гүйцэтгэлд төрийн аудитын байгууллага хяналт тавьж, аудит хийж, дүгнэлт гаргана”, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 4.5-д заасны дагуу сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Дорноговь аймгийн сонгуулийн хорооны зардлын тайланд Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-т заасныг баримтлан аудитыг хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ЗОРИЛТ:

Орон нутгийн 2023 оны нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс санхүүжүүлсэн Дорноговь аймгийн сонгуулийн хорооны сонгуулийн зардлын тайлангийн төлөвлөлт, зарцуулалтад дүгнэлт гаргаж, зөвлөмж боловсруулан аймгийн сонгуулийн хороонд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн болно.

Аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэнэ. Үүнд:

- Орон нутгийн сонгуулийн батлагдсан төсвийг холбогдох хууль, журмын дагуу төлөвлөн, хуваарилж, зарцуулсан эсэх.
- Сонгууль зохион байгуулах зардалд холбогдох хууль, журамд нийцүүлэн хяналт тавьж ажилласан эсэх.

АУДИТЫН ХАМАРСАН ХҮРЭЭ:

Аудитыг орон нутгийн нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбогдуулан Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн сонгуулийн хороонд хуваарилан зарцуулсан төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналтай холбоотой баримт материалуудыг хамруулан авч үзлээ.

АУДИТЫН АРГА ЗҮЙ:

Аудитыг Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит, Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит: Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит: Гүйцэтгэлийн аудит” стандартад заасан зарчим арга зүйд нийцүүлэн, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан ТАБ-аас аудит хийх журам, 2021 оны А/69 дугаар тушаалаар батлагдсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, А/71 дүгээр тушаалаар батлагдсан “Нийцлийн аудитын заавар, аргачлал”-ыг баримтлан шалгадагчийн сонгуулийн зардлын тайлан, холбогдох баримт материалыг шалгах, асуулга лавлагаа, тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийх, харьцуулах,

нэгтгэх, зэрэг аудитын горимыг хэрэгжүүлж, төлөвлөсөн арга зүйн дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

АУДИТАД АШИГЛАСАН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ:

Дараах хууль эрх зүйн актыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашигласан.
Үүнд:

- Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль
- Төрийн аудитын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- СЕХ-ны 2021 оны А/17 дугаар тогтоолоор баталсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”

АУДИТЫН БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА:

Аудитыг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий хянан удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер У.Оюунтүлхүүр хэрэгжүүлэн, аудитор М.Дүүрэнжаргал аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу 2023 оны 07 дугаар сарын 3-ны өдрөөс 07 дугаар сарын 14-ний өдрийн хооронд хийж гүйцэтгэлээ.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 30-ны өдөр батлан, тухайн оны 02 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсөн.

Орон нутгийн нөхөн сонгуулийг зохион байгуулахтай холбоотой улсын төсвөөс аймгийн сонгуулийн хороонд 40.3 сая төгрөгийг хуваарилсан байна.

Дорноговь аймгийн сонгуулийн хороо болон Айраг, Эрдэнэ сумдын сонгуулийн хороо, 2 хэсгийн хороод 40 гишүүний бүрэлдэхүүнтэй ажилласан байна.

Аймгийн сонгуулийн хороонд нийт 40.3 сая төгрөгийг СЕХ-ноос хуваарилснаас гүйцэтгэлээр нийт 38.9 сая төгрөгийг зарцуулж, 1.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН СОНГУУЛИЙН ХОРОО НЬ СЕХ-ООС БАТАЛСАН ТӨСВИЙГ ХОЛБОГДОХ ХУУЛЬ, ЖУРМЫН ДАГУУ ХУВААРИЛАН ЗАРЦУУЛСАН БАЙНА.

1.1. Сонгуулийн ерөнхий хороо нь аймгийн сонгуулийн хороонд 40.3 сая төгрөгийн санхүүжилтийг төлөвлөж хуваарилсан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6-д “Орон нутгийн хурлын ээлжит бус, нөхөн болон дахин сонгууль зохион байгуулахтай холбогдон гарах энэ хуулийн 10.1, 10.2, 10.3, 10.4-т заасан байгууллагуудын зардлыг Монгол Улсын Их Хурал баталж улсын төсвөөс санхүүжүүлнэ”, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 захирамжаар батлагдсан “Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам”-ын 2.1-т “Сонгуулийн ерөнхий хороо нь сонгуулийн төсвийг зохих эдийн засгийн ангиллын дагуу сонгогчийн тоо, сум дүүргийн болон хэсгийн хорооны тоо, тэдгээрт ажиллах ажилтнуудын тоог харгалзан аймаг нийслэлийн сонгуулийн хороо бүрээр хуваарилна” гэж заасан байна.

СЕХ-ны Ажлын албаны даргын 2023 оны А/19 дүгээр тушаалыг үндэслэн СЕХ-ны Ажлын албаны 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 3/240 дугаар “Сонгуулийн төсөв хүргүүлэх тухай” албан бичгийн хавсралтаар Дорноговь аймгийн сонгуулийн 3 хороо, 2 хэсгийн ажиллах зардалд 40.3 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж, хуваарийн дагуу олгосон байна.

Хүснэгт 1: Сонгуулийн ерөнхий хорооноос аймгийн сонгуулийн хороонд хуваарилсан төсөв (эдийн засгийн ангиллаар)

№	Зардлын ангилал	Төлөвлөгөө /мян.төг/	Нийт зардалд эзлэх хувь
А		1	2
1	Маягт хэвлүүлэх зардал	130.00	0.32%
2	Үнэмлэх хэвлүүлэх зардал	70.00	0.17%
3	Сонгуулийн хорооны сургалтын зардал	380.00	0.94%
4	МТБ, даамлын зардал	50.00	0.12%
5	Бичиг хэргийн зардал	800.00	1.98%
6	Шуудан, холбооны зардал	900.00	2.23%
7	Унааны зардал	2,940.00	7.28%
8	Санал авах байр бэлтгэх зардал	600.00	1.49%
9	Сурталчилгааны зардал	1,000.00	2.48%
10	Саналын хуудас, ИСР төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолт	4,736.00	11.73%
11	Мэдээ дамжуулах, шуурхай ажлын МБТ-ийн зардал	170.00	0.42%
12	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх	240.00	0.59%
13	Унаа (туршилт болон санал авах өдрийн дүн мэдээ дамжуулах)	210.00	0.52%
14	Томилолтын зардал	2,374.00	5.88%

15	Болзошгүй зардал	1,000.00	2.48%
16	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал	21,000.00	52.00%
17	МБТ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	3,000.00	7.43%
18	Саналын хуудас устгах зардал	785.04	1.94%
Нийт мөнгөн дүн		40,385.04	100.00%

СЕХ-оос аймгийн СЕХ-нд хуваарилсан төсвийн 52.0 хувийг сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал, 7.4 хувийг мэдээллийн технологийн багийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал буюу нийт 59.4 хувийг урамшуулал, хоолны зардалд, унаа болон томилолтын зардалд 25.3 хувийг зарцуулсан байна.

СЕХ-ны Ажлын албаны даргын 2023 оны А/19 дүгээр тушаал¹-ын хавсралтын дагуу төсөвт 0.7 сая төгрөгийн саналын хуудас устгах зардал нэмэгдсэнтэй холбоотойгоор аймгийн архивд хадгалагдаж буй Монгол Улсын Их Хурлын болон аймаг, нийслэл, сум, дүүргийн 2020 оны ээлжит сонгуулийн саналын хуудсыг устгах ажлыг зохион байгуулсан байна².

1.2. Аймгийн сонгуулийн хороо нь сонгуулийн ерөнхий хорооноос өгсөн заавар, аргачлалын дагуу зардлыг хуваарилсан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 захирамжаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"-ын 2.3-т "Аймаг нийслэлийн сонгуулийн хороо нь СЕХ-оос өгсөн тайлбар аргачлалын дагуу сумын сонгуулийн хороонд зардлын төсвийг хуваарилна" гэж заасан.

СЕХ-ны Ажлын албаны 2023 оны 3/172, 3/217, 3/236, 3/240 дугаар албан бичгээр орон нутгийн нөхөн сонгуулийн төсвийн санхүүжилтийг зарцуулах хуваарь, дансны жагсаалт, тайлбар аргачлалыг тодорхой тусган, олгосон байна. Олгосон санхүүжилтийг авч үзвэл дараах байдалтай байна.

Хүснэгт 2: Сонгуулийн зардлын санхүүжилтийн мөнгөн дүн (мянган төгрөгөөр)

Байгууллагын нэр	2023.05.25	2023.06.05	2023.06.12	2023.06.16	Нийт мөнгөн дүн
Сонгуулийн ерөнхий хороо	5,450.00	11,632.00	22,518.00	785.04	40,385.04

¹ Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны нөхөн болон дахин сонгуулийн аймаг, нийслэлийн сонгуулийн хороонд хуваарилах зардлын төсөв

² Дорноговь аймгийн сонгуулийн хорооны даргын 04 дугаар захирамж

СЕХ-оос олгосон санхүүжилтийг аймгийн сонгуулийн хороонд 18.8 сая төгрөг, Айраг сумын сонгуулийн хороонд 11.5 сая төгрөг, Эрдэнэ сумын сонгуулийн хороонд 10.0 сая төгрөгийг хуваарилан олгосон байна.

График 1: Сонгуулийн зардлын санхүүжилт (сонгуулийн хороогоор)



1.3. Хуваарилагдсан зардлыг 1.4 сая төгрөгөөр хэмнэж, СЕХ-ны дансанд буцаан төвлөрүүлсэн байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 захирамжаар батлагдсан "Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих" журмын 3.8-д "Сонгуулийн хороод нь хуваарилсан зардлыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэхгүй бөгөөд шаардлагатай бол дээд шатны сонгуулийн байгууллагад албан ёсоор хүсэлт тавьж шийдвэрлүүлнэ" гэж заасан.

СЕХ-оос 40.3 сая төгрөгийн санхүүжилт олгогдсоноос нийт зардлын гүйцэтгэл 38.9 сая төгрөг, зарцуулаагүй үлдэгдэл 1.4 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 3: Аймаг болон сумын сонгуулийн хорооны зардлын гүйцэтгэл (мянган төгрөгөөр)

№	Зардлын ангилал	Нийт төлөвлөгөө	Аймгийн сонгуулийн хороо		Айраг сумын сонгуулийн хороо		Эрдэнэ сумын сонгуулийн хороо	
			Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Маягт хэвлүүлэх зардал	130.0	30.0	30.0	50.0	50.0	50.0	50.0
2	Үнэмлэх хэвлүүлэх зардал	70.0	70.0	70.0	-	-	-	-
3	Сонгуулийн хорооны сургалтын зардал	380.0	380.0	380.0	-	-	-	-
4	МТБ, даамлын зардал	50.0	50.0	50.0	-	-	-	-
5	Бичиг хэргийн зардал	800.0	300.0	300.0	250.0	250.0	250.0	270.0
6	Шуудан, холбооны зардал	900.0	300.0	300.0	300.0	300.0	300.0	300.0
7	Унааны зардал	2,940.0	1,120.0	1,120.0	910.0	910.0	910.0	910.0
8	Санал авах байр бэлтгэх зардал	600.0	-	-	300.0	300.0	300.0	350.0
9	Сурталчилгааны зардал	1,000.0	300.0	-	500.0	500.0	200.0	200.0
10	Саналын хуудас, ICP төхөөрөмж авах, хүлээлгэн өгөх унаа, томилолт	4,736.0	4,736.0	4,736.0	-	-	-	-
11	Мэдээ дамжуулах, шуурхай ажлын МБТ-ийн зардал	170.0	170.0	170.0	-	-	-	-
12	Эрчим хүчний эх үүсвэр бэлтгэх	240.0	-	-	120.0	120.0	120.0	50.0
13	Унаа (туршилт болон санал авах өдрийн дүн мэдээ дамжуулах)	210.0	-	-	105.0	105.0	105.0	105.0
14	Томилолтын зардал	2,374.0	2,374.0	2,282.0	-	-	-	-
15	Болзошгүй зардал	1,000.0	1,000.0	-	-	-	-	-
16	Сонгуулийн хорооны гишүүдийн урамшуулал, хоолны зардал	21,000.0	5,400.0	5,400.0	8,400.0	8,400.0	7,200.0	7,200.0
17	МБТ-ийн гишүүн, даамлын урамшуулал, хоолны зардал	3,000.0	1,800.0	1,800.0	600.0	600.0	600.0	600.0
18	Саналын хуудас устгах зардал	785.0	785.0	785.0	-	-	-	-
Нийт мөнгөн дүн		40,385.0	18,815.0	17,423.0	11,535.0	11,535.0	10,035.0	10,035.0

Аймаг, сумдын сонгуулийн хорооны нийт зардлын гүйцэтгэлийг авч үзвэл, Айраг, Эрдэнэ сумдын сонгуулийн хороонд хуваарилагдсан зардлыг 100 хувь зарцуулж, аймгийн сонгуулийн хороо 92.6 хувийн гүйцэтгэлтэй зарцуулж, 1.4 сая төгрөгийн үлдэгдэлтэй зарцуулсан байна.

Аймаг, нийслэлийн сонгуулийн хорооны төсвийн зарцуулалтын тухай тайлбар³-ын 6-т *“Эрчим хүчний эр үүсгэвэр бэлтгэх зардлыг санал авах байрыг гэрэлтүүлэх, эрчим хүчний эх үүсвэр дутагдалтай болон цахилгаан тасарсан үед ашиглах мотор түрээслэх зориулалтаар 1 санал авах байрт 120.0 мянган төгрөгөөр тооцож хуваарилсан. Энэ зардлыг зайлшгүй хэрэгцээ шаардлагатай хэсэгт хуваарилах нь зүйтэй”* гэж заасан байна. Харин Эрдэнэ сумын сонгуулийн хороо дээрх зардлын эх үүсвэрээс бичгийн хэргийн зардалд 20.0 мянган төгрөг, санал авах байр бэлтгэх зардалд 50.0 мянган төгрөгийг зарцуулсан нь зориулалтын дагуу зарцуулсан гэж үзэхээр байна.

БҮЛЭГ 2. ОРОН НУТГИЙН НӨХӨН СОНГУУЛИЙН ЗАРДЛЫН ГҮЙЦЭТГЭЛИЙГ ЖУРМЫН ДАГУУ ТАЙЛАГНАЖ, ХОЛБОГДОХ ХЯНАЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭН АЖИЛЛАСАН БАЙНА.

2.1. Орон нутгийн хурлын нөхөн сонгуулийн зардлын гүйцэтгэлийг журмын дагуу бүртгэж, тайлагнасан байна.

Сонгуулийн ерөнхий хорооны даргын А/17 захирамжаар батлагдсан журмын 4 дүгээр зүйлийн 4.1-т *“Сонгуулийн зардлын дансны орлого, зарлагын гүйлгээнд холбогдох анхан шатны баримтуудыг зохих ёсоор бүрдүүлэн хадгалж бүртгэлийг НББ-ийн тухай хуульд заасны дагуу хөтөлнө”* гэж заасны дагуу аймаг, сумдын сонгуулийн хороод мөнгөн хөрөнгө, бараа материалын бүртгэлийг хөтөлж, ажил гүйлгээний анхан шатны баримтыг бүрэн бүрдүүлсэн байна.

Аймаг, сумдын сонгуулийн хороод нь Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн I, II хавсралтаар батлагдсан маягтын дагуу сонгуулийн зардлын тайланг тайлагнажээ.

Аймгийн сонгуулийн хороо нь зардлын тайланд болзошгүй зардлын 1.0 сая төгрөг, сурталчилгааны зардлын 0.3 сая төгрөг болон томилолтын зардлын 0.1 сая төгрөгийг буюу нийт 1.4 сая төгрөгийг Сонгуулийн ерөнхий хороонд буцаан төвлөрүүлсэн боловч гүйцэтгэл хэсэгт тайлагнасан байна.

2.2. Аймгийн сонгуулийн хорооноос сумдын зардлын зарцуулалтын талаар зөвлөмж, чиглэл өгч хяналт тавих эрхээ хэрэгжүүлэн ажилласан байна.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.10-т *“Аймгийн сонгуулийн хороо нь СЕХ-оос хуваарилсан төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу захиран зарцуулах, зохих*

³ СЕХ-ны Ажлын албаны 2023 оны 3/217 дугаар албан бичгийн нэгдүгээр хавсралт

журмын дагуу харьяалах сонгуулийн хороонд хуваарилах, зарцуулалтад нь хяналт тавих бүрэн эрхтэй” гэж заасан.

Мөн Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар тушаалаар батлагдсан *"Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих"* журмын 3 дугаар зүйлийн 3.10-т *"... аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хорооны зарцуулалтад хяналт тавина"*, 4 дүгээр зүйлийн 4.6-д *"Аймгийн сонгуулийн хорооны нягтлан бодогч сумын сонгуулийн хорооноос ирүүлсэн санхүүгийн анхан шатны баримтыг шалган, акт үйлдэн хүлээн авна..."* гэж заасан.

Аймгийн сонгуулийн хороо нь сумын сонгуулийн хороодод хөрөнгийн зарцуулалтыг эдийн засгийн ангилал хооронд гүйлгэн зарцуулахгүй байх, холбогдох тайлан мэдээ, санхүүгийн анхан шатны баримтыг НББ-ийн тухай хуулийн дагуу бүрдүүлэн ажиллах зэрэг заавар зөвлөмжийг тухай бүр өгч ажиллажээ.

Сумдын сонгуулийн хороод нь Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжийн II хавсралтаар батлагдсан маягтын дагуу тайлагнасан боловч Эрдэнэ сумын сонгуулийн хорооны төрийн сангийн харилцах дансаар хийсэн ажил гүйлгээний зардлын ангилал, гүйлгээний утга тодорхой бус, батлагдсан зардлын ямар ангиллаас зарцуулсан нь тодорхойгүй байна.

Төрийн сангаар сонгуулийн зардлын ажил гүйлгээг бараа үйлчилгээний бусад зардал /210901/-ын дансны ангиллаар хийж, зарцуулсан нь батлагдсан зардлын ангиллын дагуу зарцуулж байгаа эсэхэд аймгийн сонгуулийн хорооноос хяналт тавих боломжгүй байна.

Аймгийн Сонгуулийн хороонд толилуулах нь:

Сонгуулийн ерөнхий хорооноос орон нутгийн 2023 оны нөхөн сонгууль зохион байгуулах зардалд улсын төсвөөс 40.3 сая төгрөгийн санхүүжилт олгосныг аймаг, сумдын сонгуулийн хороод Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хууль, Сонгуулийн ерөнхий хорооны даргын 2021 оны А/17 дугаар захирамжаар батлагдсан *"Сонгуулийн төсөв хуваарилах, зарцуулах, тайлан гаргах, хяналт тавих журам"*-ын холбогдох заалтын дагуу зарцуулж, тайлагнасан байна.

